



РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Сэдэв: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын аргууд

Илтгэгч багш: Ж. Нямдэмбэрэл

ИЛТГЭЛИЙН АГУУЛГА

ОРШИЛ :

ИЛТГЭЛ БИЧИХ ҮНДЭСЛЭЛ:

ИЛТГЭЛИЙН БҮТЭЦ:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖЛИЙГ СУДЛАХ судалгааны аргачлал

1.1 ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ:

1.2 СУДАЛГАА №1.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН АРГА, ТЕХНОЛОГИ

2.1 СУДАЛГАА №2.

✓ Хүүхэд хэдийд хаана хөгждөг вэ?

2.2 СУРГАЛТЫН АРГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1.Сургалтын аргуудад сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах байдлыг судалсан судалгаа

3.2.СУДАЛГАА №6.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ТАРААХ МАТЕРИАЛ АШИГЛАН ХӨГЖҮҮЛЭХ

4.1. ТАРААХ МАТЕРИАЛЫН САН

ОРШИЛ

Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёлоо дээдэлдэг иргэн болж төлөвшихөд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлон "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөрийг" Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл", "Авьяас", "Ном" гэсэн гурван дэд хөтөлбөрийн хүрээнд 2013.08.16 ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар баталсан нь хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн шийдвэр боллоо. Монгол улсын салбар бүр хөгжин дэвжихийн үндэс нь гагцхүү багш шавийн барилдлагын нандин бүтээлч харилцаа юм. Иймээс цаашид **хүүхэд нэг бүрийн хөгжлийг ирээдүйн амьдралын баталгаа нь** хэмээн харж, үнэлсэн арга зүй, технологийг хэрэгжүүлж ирсэн ухаант багш нарынхаа хичээл зүтгэлийг дэмжин урамшуулж, түгээх ажлыг шинэ түвшинд гаргана гэдгээ амалж байна. ¹

¹ Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр 2013-2014 оны хичээлийн жилийн нээлтэн дээр хэлсэн үгнээс

Хүн үйл ажиллагааг ухамсартай хийх явцад түүний оюун ухаан хөгждөг. Ингэхдээ тэрхүү үйл ажиллагаа нь тэдний хэрэгцээ сэдэл зэргийг хангахад чиглэсэн байвал хүн тэр үйл ажиллагааг гадны шахалтгүйгээр өөрийн идэвхи санаачлагаар дуртай хийдэг байна. Үүнээс үзвэл **сургалт нь сурагчийн хэрэгцээ үйл ажиллагаанд тулгуурласан буюу сурагч төвтэй байвал үр дүнтэй байна.** Сурагчийг амжилттай сургая гэвэл түүнийг сурах олон төрлийн үйл ажиллагаанд татан оруулахаар багш хичээлээ бэлдэж зохион байгуулж явуулах шаардлагатай болж байна.³

БАГШ



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮҮХЭД НЭГ БҮРИЙН ХӨГЖЛИЙГ СУДЛАХ судалгааны аргачлал



1.2 СУДАЛГАА №1. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙН ХӨГЖЛИЙГ СУДЛАХ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

48-р сургуулийн Багш Ц.Бямбадоогийн хүүхэд нэг бүрийн хөгжлийг судлах аргачлалаас хуваалцлаа.

үнэлгээ	эйлгэлт	Сурагчдын түвшин	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	анги	бхд.	угирлууд				
						I	II	III	IV	Хичээлийн ололт
төлөөшил	оролцсэ	Ахих түвшин	• Хичээл тасгадаг, хоцордог	9а	51	18				
			• Хичээл бэлтгэл хаях ханидаггүй	9г	48	16				
			• Хичээлийн тэмдэглэл дутуу хийдэг	9д	57	31				
		Хэвийн түвшин	• Гэрийн даалгавар хийдэггүй, дутуу хийдэг	9а	51	25				
			• Хичээл тасгадаггүй	9г	48	22				
			• Хичээлийн тэмдэглэл хийдэг, дутуу	9д	57	21				
		Ахисан түвшин	• Гэрийн даалгавар дутуу хийдэг	9а	51	8				
			• Өөрийн сэтгэхүй, бодит сролцоо дунд	9г	18	10				
			• Өөрийн сэтгэхүй, бодит сролцоо сайн	9д	57	5				
	дадал хэвшил	Ахих түвшин	• Сургуулийн дстоод журам зөрчдөг	9а	51	8				
			• Бусдад сайн үлгэр дуурайлалгүй	9г	40	9				
			• Бусдыг уруу татдаг	9н	57	12				
		Хэвийн түвшин	• Бусдын болон багшийн хэлсэн үүрэг даалгаврыг биелүүлэхдээ хойрго	9а	51	43				
			• Өөрийн гэсэн үзэл бодол тогтвортой бий	9г	48	39				
			• Сургуулийн дстоод журам зөрчдөггүй	9д	57	45				
	зан чанар	Ахих түвшин	• Бусадтай харьцах харьцаанд анхаарах	9а	51	12				
			• Өөрийгөө илэрхийлэх чадвар бага	9г	40	11				
			• Өөртөө итгэх итгэл бага зэрэг	9д	57	15				
		Хэвийн түвшин	• Өөрийгөө зөв ачлгах талаар хичээлдгүй	9а	51	39				
			• Бусадтай зөв харьцдаг	9г	48	37				
			• Бусдад тусархаг	9д	57	42				
• Өөрийгөө илэрхийлэх чадвартай										

онолын үнэлгээ	ойлог	Сурагчдын түвшин	Гүйцэтгэлийн шапгуур үзүүлэлт	ингэ	бүгд	угиргууд					Жилийн үзүүлэлт
						I	II	III	IV		
Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын нэгж	ахиц	Ахиц түвшин	• Тухайн сэдвээр эзэмшлээ эрхлэх наад захын мэдлэг чадвар	9а	51	25					
			• Томьёо ашиглах чадвартай	9г	48	21					
			• Өгөгдөл дээр ажиллах чадвартай	9д	57	23					
		Хэвийн түвшин	• Тухайн сэдвээр эзэмшлээ эрхлэх мэдлэг чадвар дундаж	9а	51	21					
			• Томьёо ашиглаж бага зэргийн хувиргалт хийх чадвартай	9г	48	23					
			• Өгөгдлийг өргөтгөн ажиллах чадвартай	9д	57	24					
		Ахисан түвшин	• Тухайн сэдвээр эзэмшлээ эрхлэх мэдлэг чадвартай	9а	51	5					
			• Томьёо ашиглах олон адилтгал хувиргалт хийх чадвартай	9г	48	4					
			• Өгөгдлийг өргөтгөн бэлжүүлж ямарч орчинд хэрэглэх чадвартай	9д	57	5					
	амжилт	Ахиц түвшин	• Балшийн ёслон хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь 10% хүртэл	9а	51	23					
			• Сургалтын материалаас бодох бие даалтын бодлогын бодолт 50% аар дээш	9г	40	21					
				9д	57	27					
		Хэвийн түвшин	• Балшийн ёслон хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь 41-75% хүртэл	9а	51	20					
			• Сургалтын материалаас бодох бие даалтын бодлогын бодолт 70-80%	9г	40	13					
				9д	57	25					
		Ахисан түвшин	• Балшийн ёслон хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь 80% хүртэл	9а	51	8					
			• Сургалтын материалаас бодох бие даалтын бодлогын бодолт 90% дээш	9г	48	0					
			• Нэмэлт материалыг ашиглан бодох чадвартай байх	9д	57	5					

Эрүүл мэнд	Авъяасыг нээн хөгжүүлэх	• Өөрийн хийгээр сэтгэхүйг хөгжүүлэн ямарга зүйлд хангах хандлагыг шинэчлэх • Сурагч өөрийгөө хөгжиж байгаагаа ямар нэгэн байдлаар мэдэрч өөрийгөө хөгжүүлэх зөв сэдэл боломжийг олж авах, эрэлхийлэх • Шаардлагатай тохиолдолд математикийн хичээлээр түүнийг үүрэг, судалж урсгал, олимпиад тэмцээнд оролцож хүсэл, сонирхол, идэвх өрнөсөн байх • Алъяаа зүйлд нэг ниймСай хандаж бусад хүүхдийн хөгжлийн мэдэрч өөрийнхөө авъяасыг хөгжүүлэх арга олж
	Оюун ухаан	• Сэтгэлгээгээ хөгжүүлэх үндсийг тавьж өөрийгөө дайчилдаг болгох • Мэдлэг чадвараа үнэн зөвөөр шапгуулж асуудалд нэг талаас биш олон талаас нь хандах хандлагатай болгох • Оюун ухаанаа хөгжүүлэх арга барилын эхлэл тавигдаж түүнийгээ тогтмол хэрэглүүлдэг болгох
	Биеэ эрүүл байлгах	• Тэвчээртэй сууж хийх зүйлдээ анхаарлаа төвлөрүүлж, түүнийгээ үр дүнт мэдэрч чаддаг болгох • Цэлийн юмыг цагт нь хийж, цагийг хуваариа нарийн баримталж, цаг ашиглангаа сайжруулах • Өөрийнхөө удаад, дотроод үзэмжинд анхаарч ямар өөрөөрөө бахархах, сэтгэл хангалуун байх

Судалгааны аргачлал: Багш бүр энэ судалгааны асуулгын дагуу хүүхдүүдийн нэрийг бичиж судална.

Үр дүн: Энэ судалгаагаар Сурагчийн төлөвшил, Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг чадварын ахиц, амжилт, Авъяасыг нээн хөгжүүлэх, Эрүүл мэнд зэргийг нарийвчлан судалж байгаагаараа ач холбогдолтой юм.


Дүгнэлт: Хүүхдийг судлах нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн суурь үндэс юм.Тухайн хүүхдийг судалсны ач холбогдол нь сургалтын аргыг оновчтой

сонгох, тухайн хүүхдийн түвшинд тохирсон даалгавар өгөх түүнд тохирсон хэрэглэгдэхүүн бэлдэх нөхцөл бүрдэж байгаа юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН АРГА ТЕХНОЛОГИ

2.1 СУДАЛГАА №2

ХҮҮХЭД ХЭДИЙД ХААНА ХӨГЖДӨГ ВЭ?




СУДАЛГАА №2-ИЙН ДҮГНЭЛТ:

Дээрх графикаас харахад хүүхэд хоногийн 24 цагийн 11 цагийг буюу 45%-ийг сурч боловсрон хөгжихэд зарцуулж байдаг байна. Энэ 45%-ийн 64% - нь сургууль дээрх хичээлийн 80 минут юм.

2.2 СУРГАЛТЫН АРГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛ

Сургалтын арга нь сургалтын технологийн хамгийн чухал элемент бөгөөд түүний үндсэн үүрэг нь сургалтын зорилго, агуулга зэргийг багшийн сурган хүмүүжүүлэх болон сурагчийн сурч хөгжих арга ажиллагаагаар дамжуулж хэрэгжүүлэх явдал юм.² Философийн толь бичигт **Арга гэж юу вэ гэдэг нь зорилгодоо хүрэх зам юм** гэсэн байдаг.



² Сургалтын арга зүйн шинэчлэл Ш.Ичинхорлоо 2009

2.3 СУДАЛГАА. №3

Сурагч ямар тохиолдолд сурах үйлдлүүдийг ухамсартай дуртай хийх вэ?



СУДАЛГАА №3-ИЙН ДҮГНЭЛТ:

Багш сурагчийн өмнөөс сурах үйлдлүүдийг хийхгүй байх, үүний оронд сурагч сурах үйлдлүүдийг өөрөө хийх нь зүйтэй. Алтан дүрэм: 2

**Багш сурагчдад тухайн хичээлийг судлах нь хүнд хэцүү гэсэн ойлголт
төрүүлэхгүй байх, тухайн хичээлийн сонирхолтой талыг ямагт
сурагчдад мэдрүүлж байх**

2.5.СУДАЛГАА №4. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХИЙН СУРГАЛТЫН ЯМАР АРГА ХЭРЭГЛЭВЭЛ ЗОХИХ - ийг судалсан судалгаа

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн тулд сургалтын
ямар ямар арга хэрэглэвэл илүү үр дүнтэй вэ? гэдгийг
тодруулах

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ:

1. Сургалтын ямар ямар арга байдаг вэ?
2. Багш нар сургалтын ямар ямар аргуудыг түлхүү хэрэглэдгийг судлах
3. Тэдгээр аргуудаас ямар арга нь Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд илүү үр
дүнтэйг судалж, судалгаа хийх
4. Судалгааны мэдээлэлд боловсруулалт хийж, дүгнэлт гаргах

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Санамсаргүй түүврийн аргаар төрийн өмчийн ҮУПК-ийн сургуулиудын
суралцагч болон багш нарыг хамруулсан. Багш нарын 55% нь байгалийн ухааны,
45% нь нийгмийн ухааны багш нар байлаа.

СУДАЛГААНЫ ОБЪЕКТ: Сургалтын аргууд

СУДАЛГААНЫ АРГА:


Түүврийн ярилцлага, хос харьцуулалт, баримт бичгийн, ажиглалт,
туршилтын, нээлттэй асуулгын, контент анализын, статистикийн, математик
боловсруулалтын аргуудыг хэрэглэж, excel программыг ашиглалаа.

СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ:

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн тулд сургалтын уламжлалт аргуудаас
илүүтэйгээр сургалтын идэвхитэй аргуудыг голлон хэрэглэх нь илүү үр дүнтэй.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:





Нэмэлт аргуудаас санаа нэмэрлэвэл :


АХА тэмцээний арга: Бүх төрлийн цээжлэх үйл хийлгэхэд мөн тухайн сэдвийг нэгтгэн дүгнэхэд маш зохимжтой. Сурагчдад сонирхолтой, өрсөлдөөн бий болно,

Цахим тоглоомын арга: Бага ангийн сурагчдад илүү тохиромжтой. Сургалтанд зориулсан цахим тоглоомын программ зохиох, сургалтын цахим тоглоомын стандарт боловсруулах шаардлагатай. Муу тал нь байнга хэрэглэх хэрэггүй.

Бичлэг ашиглах арга: Сурагчдыг сэдэлжүүлэхдээ, хичээлийг бататгахдаа БАГШ бид ийм сэдэв үзнэ гэд байхын оронд тухайн сэдэвтэй холбоотой 3 минутын бичлэг үзүүлэхэд сурагчдын анхаарал аяндаа төвлөрнө.

Онлайн тестийн арга: Ахлах ангийн сурагчдад бататгах, шалгах, нэгтгэн дүгнэх, үнэлэх хэлбэрийн хичээлүүдэд зохимжтой. Сайн тал нь цаг хугацаа

хэмнэнэ. Эргэх холбоотой. Муу тал нь өөр хүнээр хийлгэх боломжтой. Гэхдээ энэ асуудлыг шийдэж Онлайн Олимпиад зохион байгуулж байна.



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Энэ судалгаанаас дүгнэлт хийхэд хамгийн оновчтой аргууд нь:

- Үндсэн аргуудаас сэдэлжүүлэх болон үзүүлэн таниулах арга
- Идэвхижүүлэх аргуудаас асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, судлан шинжлэх, венийн диаграмм, дүрд тоглох, аялал музейн, эвлүүлгийн, тайлбартай дасгал, хэсэгчилсэн эрэл хайгуул хийх, булангийн, маргаан гаргах, KWL, цахим тоглоомын зэрэг аргууд дийлэнхи ихэнхи хувийг эзэлсэн байна. Сургалтын арга нь сургалтын технологийн бүх элементийг хооронд нь холбож эдгээрийг хөдөлгөөнд оруулах үүрэгтэй. Ямар ч

нөхцөлд хэрэглэж болдог шилдэг /универсал/ арга гэж байдаггүй ба арга болгон тодорхой зорилтыг шийдвэрлэдэг учир багш тодорхой сэдэв зорилтыг амжилттай шийдэж чадах тийм аргыг хослуулан хэрэглэх нь зүйтэй юм. Мөн мэдээлэл технологийн дэвшлийг сургалтандаа оновчтой ашиглаж сурах шаардлага зүй ёсоор гарч байна.

Багш ямар нэг аргыг хэрэглэхэд түүний сургах үйлдэл нь сурагчаар сурах үйлдлийг хийлгэж байвал багш аргаа оновчтой зөв сонгож авсан гэж үзэж болно.

- Харин багш сурган хүмүүжүүлэх тодорхой үйлдлийг хийгээд байхад сурагч сурах үйлдлээ хийхгүй өөр зүйл хийж байвал багш аргаа оновчгүй сонгосон гэж үзнэ.
- Иймд багш өдөр тутмын хичээлд аргуудыг хослуулан хэрэглэвэл хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд илүү түлхэц болно.
- Багш хичээлээ судлахаас гадна, хүүхдүүдээ мэдлэгийн түвшингээр судлаад хүүхэд бүрт тохирсон хэрэглэгдэхүүн ашиглан бүх хүүхдийг үүрэгжүүлбэл хүүхэд нэг бүртэй ажиллаж чадах юм.
- Нэгэнт хүүхэд бүрийг хөгжүүлэхийн тулд

$$\begin{aligned} &= \\ &\text{Уламжлалтарга} \\ &+ \\ &\text{идэвхтэй сургалтын арга} \\ &+ \\ &\text{мэдээлэл технологийн хэрэгслийг} \end{aligned}$$

ашиглахтай хослуулбал үр дүнтэй гэдэгтэй бүгд санал нийлж байвч яагаад сургалтын 80 орчим хувь нь уламжлалт аргаараа явагдаад байна вэ?


ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Сургалтын аргуудад сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг ашиглагдах

байдлыг судалсан судалгаа

Сургалтын аргууд		Биет	Д	проектор	Ном сурах бичиг	Туршилтын багаж	Т Самбар шохой	Тараах материал	Х Д	Цахим хэрэглэгдэх	онлайн тест	тест
У	Харилцан яриа	0	2	2	2	5	5	3	2	2	1	0
	Сэдэлжүүлэх	3	4	4	4	4	1	4	4	2	0	0
	Мэдлэг бүтээлгэх	0	4	2	5	2	5	5	2	2	1	3
	Үзүүлэн таниулах	2	3	3	5	3	3	4	2	2	0	3
	Практик дасгал	1	3	2	5	2	2	5	2	1	1	3
	Бичвэртэй ажиллуулах	3	3	3	3	3	2	3	2	2	1	4
Идэвхиж	Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх	0	3	4	4	3	5	5	2	2	0	4
	Маргаан гаргах	1	4	2	4	0	4	3	2	2		3
	Хэсэгчилсэн эрүүл хайгуул хийх	0	4	3	5	3	5	4	5	5	1	3
	Инсертийн	0	0	2	5	3	5	4	1	3		4
	Судлан шинжлэх	5	4	4	5	3	5	4	4	4	2	2
	Оюуны дайралт хийх	0	0	2	5	4	4	3	3	3	0	4
	Хэлэлцүүлгийн	1	3	3	5	3	5	3	2	2	2	4
	Эвлүүлгийн	0	3	2	5	4	5	4	2	2	1	3
	Дүрд тоглох	4	5	0	5	5	5	5	5	1	0	0
	Марафон бичлэгийн	0	1	4	4	3	5	3	1	1	1	2
	Зэрэгцүүлсэн тэмдэглэл хөтлөх	0	3	3	5	2	5	4	0	1	1	3
	Венийн диаграм	1	4	4	5	1	5	3	0	0	0	3
	Жишээн дээр суралцах	3	3	4	4	4	3	5	2	3		4
	Тайлбартай дасгал	2	5	4	4	3	5	4	4	0	0	3
	Аялал музейн	5	5	0	1	0	0	1	4	3	1	3

Хэлэлцүүлгийн тор	0	3	3	4	2	5	3	2	1	1	5
Зүйр цэцэн үг	0	0	0	3	0	4	2	0	0	0	0
Тоглоомын	2	4	0	1	3	2	3	2	0	0	1
Булангийн	0	2	1	5	3	3	4	0	0	0	2
Төсөл боловсруулах	0	0	3	5	5	5	4	0	2	0	5
Цахим тоглоомын	0	5	1	1	0	0	4	3	4	4	0
KWL	2	3	4	5	5	5	4	4	3	1	3
Авах оноо	140	140	140	140	140	140	140	140	140	140	140
Авсан оноо	35	80	64	114	78	108	93	54	49	19	73
хувь	25%	57%	50%	81%	55%	77%	66%	38%	35%	13%	52%



Судалгааны үр дүн: Сургалтын хэрэглэгдэхүүнээс хамгийн түгээмэл нь ном сурах бичиг 81%, самбар шохой 77%, тараах материал 65% байна. Мөн ихэнх хэрэглэгдэхүүнийг бэлтгэхэд цаг хугацаа их ордог учраас бид уламжлалт аргаа сонгоод байдаг юм байна.

Дээрх судалгаагаар тараах материал ашигладаггүй сургалтын арга гэж байдаггүй ба тараах материал нь сурагчдын түвшинд тохируулж ажиллах, **хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд** хамгийн зохимжтой сургалтын хэрэглэгдэхүүн юм байна. Тийм учраас бүгдээрээ тараах материалын сантай больё.

ДҮГНЭЛТ

Илтгэл бичээд дараах дүгнэлтийг гаргалаа. Багш бичиг цаасанд дарагдах биш хичээлийн өмнө, явцад, хойно хүүхдээ судлах, судалгаан дээрээ үндэслэн сургалтын арга, хэрэглэгдэхүүнийг сонгох хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ажлаа хийх нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нэг том алхам болно. Хүүхдийг олон талаас сонирхолтой аргуудаар тухайн нас сэтгэхүйд тохируулан хөгжүүлэх хэрэгтэй юмаа.

Хүүхдийг олон талаас сонирхолтой аргуудаар тухайн нас сэтгэхүйд тохируулан хөгжүүлэх хэрэгтэй юмаа. Иймээс мэргэжил нэг олон багш нараасаа суралцаж туршлага хуваалцах гэх мэт хөгжих асуудал нэн чухал. Багшийн гараа эхэлж байгаа залуу багш нарын хамгийн түрүүнд зорилго сурган хүмүүжүүлэх арга, технологид суралцах, шинэ санаагаа авах том боломж байдаг билээ.

Ном зүй:

1. “Багшийн ном” В.Э. Иленков 1964 он
2. С.Батхуяг “Боловсрол судлалын ерөнхий үндэс”
3. Бадамсамбуу,З.Нэргүй. Сургалтын арга хэрэгсэл
4. Ц.Баасандорж “Сургалтын арга” МУБИС.2008
5. Интернет эх сурвалжууд-Давалгаа.мн
6. Ичинхорлоо.Ш “Сурах арга”
7. Ичинхорлоо.Ш. Сургалтын аргазүйн шинэчлэл.
8. Т.Оюун. “Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй”
9. Н.Цэдэвсүрэн “Багшийн ном”
10. С.Эрдэнэцэцэг 2010он УБ “Багш боловсролын үндэс” 11. JICA.Хэрэглээнд суурилсан сургалт зохион байгуулах аргазүй.